

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ,  
ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 1/1/1/60/1/51/1/217

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.5, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг тус тус удирдлага болгон ТУШААХ нь:


1. "Хилийн хориг тавих, цуцлах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын болон Иргэний харьят, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын алба хаагчдад танилцуулж, үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний харьят, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дэд дарга нарт даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дарга нарын хамтарсан 2009 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Журам батлах тухай" 133, 499, 535, 07, 44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалыг 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.





## Нэг. Нийтлэг үндэслэл

ЗӨВШӨӨРӨВ:  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,  
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ  
  
М.ЭНХ-АМГАЛАН

ХИЛИЙН ХОРИГ ТАВИХ, ЧУЦЛАХ ЖУРАМ,

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26, 27 дугаар зүйлүүдэд заасан хэрэг бургэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллага /Цаашид “Эрх бүхий байгууллага” гэнэ/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэгт сэргээгсэн хүн, шалгагдаж буй этгээд, ял эдэлж буй ялтан болон эрэн сурвалжлагдаж байгаа этгээд /Цаашид “Зорчигч” гэнэ/, эд зүйлс, тээврийн хэрэгслийг улсын хилээр үл нэвтрүүлэх талаар Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагатай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллахад дагаж мөрдөнө.

1.2. Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний өрөнхий газар нь Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурорын зөвшөөрөл<sup>1</sup> бүхий мэдээллийн дагуу зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслиййг улсын хилээр үл нэвтрүүлэх арга хэмжээ авна.

Хоёр.Хил дээр хориг тавих талаар мэдээлэл солилцох

2.1.Эрх бүхий байгууллага нь улсын хил дээр зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг зөвхөн дор дурдсан үндэслэлээр saatuuulna:

2.1.1. сэжигтэн, яллагдагчаар татагдсан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн талаар;

2.1.2.оргон зайлсан эсхүл оргон зайлах үндэслэл бүхий сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтын талаар;

2.1.3.годаадад хувийн хөргээр зорчих, цагаачлах эрхийг нь хуулиар түдгэлзүүлсэн этгээдийн талаар;

2.1.4.хуурамч эсхүл хүчин төгөлдөр бус баримт бичгээр Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэсэн буюу нэвтрэхийг завдсан этгээдийн талаар;

#### 2.1.5.гэмт хэрэгт сэргэгдэж буй хүний талаар:

2.1.6.эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлс, тээврийн хэрэгслийн талаар.

2.2. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хойшлуулшгүй ажиллагааны явцад хил дээр хориг тавих хүсэлтэнд дараах мэдээллийг тусгаж, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан бичгээр хүргүүлнэ:

2.2.1. зорчигчийн ургийн овог, эцэг эхийн болон өөрийн нэр, гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичигт бичигдсэн англи галиг бүхий овог нэр, төрсөн он, сар, өдөр, иргэншил, регистр, гадаад паспортын дугаар, шаардлагатай

<sup>1</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 206 дугаар зүйл заасны дагуу эрх бүхий байгууллагаас эрэн сурвалжлах арга хэмжээг зохион байгуулна.

тохиолдолд цахим үнэмлэх, тэдгээрийн хуулбар, гэрэл зураг, биеийн содон шинж тэмдэг, хоч болон боломжтой бусад мэдээлэл;

2.2.2.тээврийн хэрэгслийн улсын дугаар, марк, өнгө, арал, хөдөлгүүрийн дугаар;

2.2.3.эд зүйлийн тодорхойлолт, содон шинж тэмдэг, фото зураг;

2.2.4.мэдээллийг хариуцах газар, хэлтэс, алба хаагчийн овог нэр, албан тушаал, цол, харилцах утас болон факсын дугаар.

2.3.Хойшлуулшгүй ажиллагааны явцад эрх бүхий байгууллага улсын хил дээр хориг тавих үндэслэл бүхий зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийн талаар жижүүрийн прокуророос зөвшөөрөл авч, албан бичгийг тусгай шуудангаар, бие төвлөөлөгч /яяралтай тохиолдолд факсаар/-өөр Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт шууд хүргүүлж, мэдээлэл солилцно.

2.4.Эрх бүхий байгууллагаас хилийн хориг тавих хүсэлтийг амралтын болон ажлын бус цагаар Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газарт хүргүүлсэн бол дараагийн ажлын эхний өдөр прокурорын зөвшөөрөл бүхий албан бичгийг нөхөн хүргүүлж, баталгаажуулна.

2.5.Хилийн шалган нэвтрүүлэх боомтууд нь Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Шалган нэвтрүүлэх газраас мэдээллийн нэгдсэн санд албан ёсоор оруулаагүй зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг saatuuлахаар санд оруулсан зорчигч, эд зүйлийг зөвшөөрөлгүй улсын хил нэвтрүүлэхийг хориглоно.

2.6.Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нь эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хилийн хориг тавих хүсэлтийг хүлээн авч, бүртгэлд оруулсан тухай мэдээллийг ажлын 3 хоногт багтаан тухайн эрх бүхий байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

#### **Гурав.Саатуулах ажиллагаа болон мэдээллийн үр дүнг тооцох**

3.1.Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нь saatuuлсан зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг шалгагдаж буй байгууллагад нотломжкоор хүлээлгэн өгнө.

3.2.Хилийн хориг тавих мэдээллийг өгсөн байгууллага нь saatuuлсан зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг нотломжийн хамт хүлээн авах арга хэмжээг нэн даруй<sup>2</sup> авна.

3.3.Нотломжид saatuuлсан он, сар, өдөр, тухайн боомтын нэр, хил нэвтрэх чиглэл, аяллын дугаар, зорчгийн овог нэр, иргэншил, улсын хил нэвтрэх эрхийн баримт бичиг болон регистрийн дугаар, гадаад паспортын дугаар, тээврийн хэрэгслийн дугаар, төрөл, марк, эд зүйлийн шинж байдал зэргийг тодорхой тусгаж 2 хувь үйлдэнэ.

3.4.Саатуулсан этгээдийн улсын хил нэвтрэх баримт бичиг болон бусад баримтыг Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраар дамжуулан мэдээлэл ирүүлсэн байгууллагад шилжүүлнэ.

3.5.Эрх бүхий байгууллага хойшлуулшгүй ажиллагааны явцад хил дээр saatuuлагдсан этгээдийг saatuuлсан болон түүний хаана байгааг 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хурсэн гишүүн, төрөл садангийн хүн, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг олгоно.

3.6.Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар нь улсын хилээр үл нэвтрүүлэх зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийн талаарх мэдээллийг сар бүрийн сүүлийн өдөрт багтаан прокурорын байгууллагатай тодотгож, бичгээр тэмдэглэл үйлдэнэ.

3.7.Хилийн хоригийг цуцлах тухай эрх бүхий байгууллагын хүсэлтийг прокуророор уламжлуулан тухай бүр Иргэний харьялал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт албан бичгээр хүргүүлнэ.

<sup>2</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн 2011 оны "Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай" 17 дугаар тогтоопын 6.3-т "Хуулийн 58 дугаар зүйлийн 58.6-д заасан "нэн даруй" гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд гэж ойлгоно."

3.8.Зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг хилээр үл нэвтрүүлэх хоригийг дараах тохиолдолд цуцална:

3.8.1.сэжигтэн яллагдагчид холбогдох хэрэг, үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгосон прокурорын хүчин төгөлдөр болсон тогтоол;

3.8.2.анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

3.8.3.улсын хил дээр саатууллагдсан зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг эрх бүхий байгууллагаад нотломжоор хүлээлгэж өгсөн.

Эрх бүхий байгууллагаас хилийн хориг тавихтай холбоотой мэдээллийг үнэн зөв өгөх үүргийг хүлээх бөгөөд буруу мэдээллээс үүссэн үр дагаврыг тухайн байгууллага хариуцна.

**Дөрөв: Бусад зүйл**

4.1.Эрх бүхий байгууллагууд нь зорчигч, эд зүйлс, тээврийн хэрэгслийг улсын хилээр үл нэвтрүүлэх тухай хориг тавьсан, цуцалсан болон хойшлуулшгүй тохиолдолд хориг тавьсан талаарх бүртгэлийг тус бүртээ хөтлөх бөгөөд нэгдсэн бүртгэлийг Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар хариуцаж, шаардлагатай лавлагаа мэдээллээр хангана.

Нэгдсэн бүртгэлийг эрх бүхий байгууллагад цахим сүлжээнд холбогdon мэдээлэл өгч болно.

4.2.Энэ журмын хэрэгжилтийн явцад гомдол, мэдээлэл болон шаардлагыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн аваагүй бол энэ талаарх гомдол, мэдээллийг иргэн, хуулийн этгээд нь Иргэдээс тэрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу дээд шатны байгууллагад гаргаж болно.

4.3.Гадаадад зорчих эрхийг нь түдгэлзүүлсэн этгээд хувийн болон албан ажлаар гадаад улсад зорчих, эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагаар прокурорын байгууллагад хандаж, зөвшөөрөл авсан тохиолдолд прокурорын байгууллагын хүсэлтийг үндэслэн зорчигчийг хилээр үл нэвтрүүлэх хориг тавих хүсэлт гаргасан байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр түр хугацаагаар цуцалж болно.

4.4.Энэ журмын 4.3-т зааснаар зорчигчийг хилээр үл нэвтрүүлэх хоригийг түр цуцалсан тохиолдолд хориг тавигдсан этгээд Монгол Улсын хилээр эргэн орж ирсэн үеэс эхлэн зорчих эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг хэвээр үргэлжлүүлнэ.

4.5.Энэ журамд заасны дагуу хилийн хориг тавих, цүцлах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх алба /Эрүүгийн цагдаагийн газар/, ИХШХЕГ-ын Шалган нэвтрүүлэх газар улирал тутам тусын байгууллагын удирдлагад танилцуулна.

4.6.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

